



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 445

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 24,093,636.63 (хорин дөрвөн сая ерэн гурван мянга зургаан зуун гучин зургаан төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий фургон маркийн, 40-50 ӨВР улсын дугаар, 374100B0452139 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, нийт үнийг 3,500,000.00 (гурван сая таван зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа, Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газрын дарга А.Нямдаваа нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005906
23-r_huraldaan.docx